

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган Угалзтийн нурууны Байгалийн цогцолборт газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Балжинням

Утас: 70432545

цахим хаяг: baljinyam.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	4
2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Зөвлөмж	11
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил
МУНБЦГ	Мянган Угалзтайн нурууны байгалийн цогцолборт газар

1.Аудитын санал дүгнэлт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.14 № 2/63
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газар, хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газар, хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэгтэйгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,247,755.59</u>	<u>43,572,255.59</u>
33	АВЛАГА	377,786.30	377,786.30
335	Бусад авлага	377,786.30	377,786.30
3351	Байгууллагаас авах авлага	377,786.30	377,786.30
35	БАРАА МАТЕРИАЛ	37,869,969.29	43,194,469.29
354	Хангамжийн материал	37,869,969.29	43,194,469.29
35410	Бичиг хэргийн материал	00.00	68,500.00
35470	Бусад хангамжийн материал	37,869,969.29	43,125,969.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>168,583,163.02</u>	<u>154,983,786.22</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	168,583,163.02	154,983,786.22
392	Биет хөрөнгө	138,143,163.06	124,653,786.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,134,501.12	49,134,501.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,968,162.56	-4,452,243.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,157,000.00	47,657,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-25,500,000.00	-12,894,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,221,878.47	77,608,678.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,846,343.78	-47,995,939.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,520,331.39	13,520,331.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,576,041.58	-7,924,541.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
393	Биет бус хөрөнгө	30,439,999.96	30,329,999.92
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-110,000.04	-220,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>206,830,918.61</u>	<u>198,556,041.81</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>206,830,918.61</u>	<u>198,556,041.81</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	206,830,918.61	198,556,041.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	47,571,030.00	47,571,030.00
51101	Өмч: - төрийн	47,571,030.00	47,571,030.00
512	Хуримтлагдсан үр дүн	151,080,136.49	142,805,259.69
51210	Өмнөх үеийн үр дүн	151,080,136.49	151,080,136.49
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,274,876.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,179,752.12	8,179,752.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>206,830,918.61</u>	<u>198,556,041.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	352,330,800.00	252,663,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,417,000.00	18,140,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,417,000.00	18,140,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,417,000.00	18,140,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	254,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,757,000.00	17,886,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,913,800.00	234,522,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,878,800.00	234,522,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,878,800.00	234,522,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	272,964,899.54	258,777,976.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,964,899.54	258,777,976.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	223,849,630.69	250,416,666.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,399,534.15	122,805,281.77
210101	Үндсэн цалин	93,041,434.15	95,959,781.77
210102	Нэмэгдэл	19,613,800.00	24,101,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,744,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,102,300.00	17,102,300.00
210201	Тэтгэврийн даатгал	12,035,000.00	12,034,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,266,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,400.00	1,013,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	253,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	2,533,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,326,300.00	6,071,610.00
210301	Гэрэл, цахилгаан	2,057,900.00	1,783,500.00
210302	Түлш, халаалт	4,733,900.00	2,958,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,534,500.00	1,329,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,547,150.00	14,480,100.00
210401	Бичиг хэрэг	723,700.00	427,600.00
210402	Тээвэр, шатахуун	13,950,450.00	12,424,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,386,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	242,400.00
2105	Нормативт зардал	174,200.00	174,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	174,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	365,500.00	340,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	124,500.00	99,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	241,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,202,000.00	2,219,800.00
210702	Дотоод албан томилолт	1,202,000.00	2,219,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,464,347.00	60,709,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,659,547.00	59,947,138.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	297,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,500.00	57,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,268,299.54	26,512,976.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	571,600.00	526,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,696,699.54	25,986,176.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,115,268.85	8,361,310.23
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,115,268.85	8,361,310.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,115,268.85	8,361,310.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>79,365,900.46</u>	<u>-6,114,876.80</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,160,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	2,160,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,160,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>79,365,900.46</u>	<u>-8,274,876.80</u>

2.3. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	151,080,136.49	206,830,918.61
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	151,080,136.49	206,830,918.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	151,080,136.49	206,830,918.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,274,876.80	-8,274,876.80
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,571,030.00	8,179,752.12	142,805,259.69	198,556,041.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>340,573,800.00</u>	<u>234,776,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	660,000.00	254,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	660,000.00	254,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	660,000.00	254,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	660,000.00	254,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,913,800.00	234,522,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	250,878,800.00	234,522,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	250,878,800.00	234,522,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>296,473,800.00</u>	<u>234,776,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	296,473,800.00	234,776,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	247,358,531.15	226,414,989.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,399,534.15	122,805,281.77
210101	Үндсэн цалин	93,041,434.15	95,959,781.77

210102	Нэмэгдэл	19,613,800.00	24,101,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,744,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,102,300.00	17,102,300.00
210201	Тэтгэврийн даатгал	12,035,000.00	12,034,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,266,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,400.00	1,013,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	253,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	2,533,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,326,300.00	6,071,610.00
210301	Гэрэл, цахилгаан	2,057,900.00	1,783,500.00
210302	Түлш, халаалт	4,733,900.00	2,958,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,534,500.00	1,329,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,352,950.00	14,548,600.00
210401	Бичиг хэрэг	583,700.00	496,100.00
210402	Тээвэр, шатахуун	15,896,250.00	12,424,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,386,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	242,400.00
2105	Нормативт зардал	174,200.00	174,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	174,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	365,500.00	340,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	124,500.00	99,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	241,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,202,000.00	2,219,800.00
210702	Дотоод албан томилолт	1,202,000.00	2,219,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,459,947.00	62,625,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,655,147.00	61,863,138.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,500.00	57,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,975,800.00	526,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	571,600.00	526,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,115,268.85	8,361,310.23
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,115,268.85	8,361,310.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,115,268.85	8,361,310.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	243,776,800.00	226,414,989.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	243,776,800.00	226,414,989.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	243,776,800.00	226,414,989.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	126,683,600.00	122,805,281.77
210101	Үндсэн цалин	99,838,100.00	95,959,781.77
210102	Нэмэгдэл	24,101,200.00	24,101,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,744,300.00	2,744,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,102,300.00	17,102,300.00
210201	Тэтгэврийн даатгал	12,034,900.00	12,034,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,266,800.00	1,266,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,013,500.00	1,013,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	253,400.00	253,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,533,700.00	2,533,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,373,900.00	6,071,610.00
210301	Гэрэл, цахилгаан	1,783,500.00	1,783,500.00
210302	Түлш, халаалт	4,260,500.00	2,958,210.00
210303	Цэвэр, бохир ус	1,329,900.00	1,329,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,916,800.00	14,548,600.00
210401	Бичиг хэрэг	496,100.00	496,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,792,300.00	12,424,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,386,000.00	1,386,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	242,400.00	242,400.00
2105	Нормативт зардал	174,200.00	174,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	174,200.00	174,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	340,600.00	340,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,600.00	99,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	241,000.00	241,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,219,800.00	2,219,800.00
210702	Дотоод албан томилолт	2,219,800.00	2,219,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,438,800.00	62,625,798.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,634,000.00	61,863,138.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	148,500.00	148,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,000.00	297,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,500.00	57,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	526,800.00	526,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,800.00	526,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	243,776,800.00	226,414,989.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	241,776,800.00	226,160,989.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,000,000.00	254,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	254,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	12.00	12.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	12.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	03.00	03.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мянган Угалзтийн нурууны Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, бараа материалын тооллого тооцоо хийгээгүй, өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг алдаа зөрчилтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 02 дугаар сарын 16-наас 2022 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны нь салбарын бодлогыг оновчтой хэрэгжүүлэх замаар Алтайн аргаль хонины тогтвортой өсөж үржих нөхцөлийг ханган, нутгийн иргэдийн оролцоотойгоор байгалийн нөөц баялгийг хамгаалах зохистой ашиглах менежментийг бий болох зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо БОАЖ яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мянган Угалзтийн нурууны Байгалийн цогцолборт газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 272,9 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 5,4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.2 сая төгрөгөөр буюу 4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Оны эхэнд байгууллагаас авах авлага 0,3 сая төгрөг байсан бол тайлант онд авлага барагдаагүй оны эцэст авлага 0,3 сая төгрөг байгаа нь эзэн холбогдогч нь тодорхой бус шалтгааны улмаас авлага барагдахгүй нөхцөл байдал үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43.2 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 168.5 сая төгрөг, оны эцэст 154.9 сая төгрөг болж 13.6 сая төгрөгөөр буурсан нь 25.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан болон элэгдлийн 25,9 сая төгрөгийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн дансны оны эхний үлдэгдэл 206.8 сая төгрөг байсан оны эцэст 198.5 сая төгрөг болж тайлант онд 8.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн дансны нөлөөлөл байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мянган Угалзтийн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 245.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 245.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тус байгууллагын 236.5 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 236.5 сая төгрөгийн төсөв баталснаас 234,5 сая төгрөгийг улсын төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 2,0 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 234,5 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 0,2 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 226,4 сая төгрөгийг зарцуулж 8,3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Өөрийн орлогын төлөвлөгөө 1,7 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 226,4 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 3,3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,3 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 147 хугацаандаа оруулсан 4 мэдээлэл хугацаа болоогүй, мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 17, зарлагын 2 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, нийт зөвлөмжийн хэрэгжилт 66 хувьтай хэрэгжсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан шатахууны жолоочийн замын тооцооны хуудасны тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргаагүй, 5, 10 саруудад шатахуун зарцуулж ямар ажилд явсан нь тодорхой бус, баримтын бүрдэл дутуу шатахуун зарцуулсан, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг үндэслэн “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана. гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

2. Үндсэн үйл ажиллагааны өөрийн орлого бүрдүүлэлт

2.1 Илрүүлэлт: Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1.7 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн зөрчил дутагдал илэрлээ.

2.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

3.1. Тооцоо тооллоготой холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан өвс, хужир шүүний үлдээдлийн тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй 4.4 сая төгрөгийн алдаа зөрчил дутагдал илэрлээ.

3.2 Өгсөн зөвлөмж Хөрөнгө болон бараа материал дутагдах эрсдэл үүсэхээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэснийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

4. Анхан шатны баримттай холбоотой

4.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа и баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг N баримтаар баталгаажуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/сая.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мянган Угалзат байгалийн цогцолборт газар	4	15.7	0	0,0	0	0,0	0	0,0	4	15.7

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР